

НИЙСЛЭЛИЙН АМГАЛАН АМАРЖИХ ГАЗАР

2017 ОНЫ ГОМДОЛ, САНАЛ, ТАЛАРХАЛД ХИЙСЭН ДҮГНЭЛТ.

- ❖ 2017 онд бүгд 26 гомдол, санал, талархал ирсэн.
Үүнийг төрлөөр ангилбал:
 - Гомдол -19(73.1%)
 - Хүсэлт – 1(3.8%),
 - Талархал – 6(23.1%). Үүнээс манайд хамааралгүй-1
- ❖ Ирсэн 19 гомдлыг ангилахад:
 - Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой – 13(68.4%),
 - Ёс зүй харилцаа хандлагатай холбоотой – 6 (31.6%)
- ❖ Гомдлыг судласан байдлаар:
 - Үндэслэлтэй гэж үзсэн – 13(68.4%)/ 2 гомдол нь 1 иргэний гаргасан давхардаж өгсөн гомдол/
 - Үндэслэлгүй гэж үзсэн - 6(31.6%)
- ❖ Талархал, гомдол, санал хүсэлтийг ирсэн хэлбэрээр нь.
 - ЗГ-ын 11:11 өргөдөл гомдлоор - 12(46.1%)
 - 1800-1200 тусгай дугаарын утас – 4(15.4%) буюу
 - Байгууллагад өөрийн биеэр ирсэн- 7(26.9%)
 - Утсаар гомдол мэдүүлсэн -3(11.5%)
- ❖ Гомдол, санал, талархалын дагуу хэрэгжүүлсэн ажил:
 - Эмч нарын ярианд танилцуулж, анхааруулсан - 20(76.9%)
 - Эмч нарт талархал илэрхийлж баяр хүргэсэн – 5(19.2%)
 - Тасгийн чанарын багийн хурлаар хэлэлцсэн – 4(15.4%)
 - Эмч, эмнэлгийн ажилтны ёс зүй харилцаа хандлагын зохисгүй үйлдлийг анхааруулж, үйлчлүүлэгчээс уучлалт гуйж, эвлэрүүлэн зуучилсан – 3(11.5%)
 - Цалингийн арга хэмжээ авагдсан -1 их эмч(3.8%)

- ❖ Гомдол, хүсэлт, талархалыг шийдвэрлэсэн байдлаар нь:
 - Хугацаанд нь шийдвэрлэсэн – 26 (100%)
 - МХГазраар шалгагдаж байгаа гомдол-1
- ❖ Гомдол, хүсэлт /20/ гарсан тасгаар нь үзэхэд :
 - Төрөх тасаг – 5(25.0%)
 - Хүлээн авах, яаралтай тусламжийн тасаг – 7(35.0%)
 - Жирэмсний эмгэгийг эмчлэх тасаг -6(30.0%)
 - Нярайн тасаг – 1(5.0%)
 - Амбулатори -1(5.0%)

Гомдол, санал, хүсэлтэд дүгнэлт хийхэд эмч, эмнэлгийн мэргэжилтний гомдолд өртөх шалтгаан нь үзүүлсэн тусламжийн талаар үйлчлүүлэгчид харилцан тайлбарлах, зөв ойлголцол үүсгэж чадаагүйгээс гомдол гарах нөхцөл болсон байна. Ялангуяа хүлээн авах, яаралтай тусламжийн тасгаар үйлчлүүлэгч болон жирэмсний эмгэгийг эмчлэх тасагт хэвтэн эмчлүүлэгчийн гомдол санал ихэнх хувийг эзлэж байна. Иймд эмч, мэргэжилтний үйлчлүүлэгчдэд зөвлөгөө өгөх ур чадварыг сайжруулах, ажлын ачааллыг бууруулах нь чухал байна.

ЧАНАРЫН АЛБА